



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/395

Мөрөн сум

Малын бруцеллёз өвчнөөс урьдчилан
Сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
Зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/276 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх эм тугал, хурга, ишгийг хамруулан 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Бруцеллёзын дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан олгож, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, гүйцэтгэлийн болон технологийн явцад хяналт тавьж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П. ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712011185



Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 31 өдрийн А/335
захирамжийн нэгдүгээр хавсралт

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2024 ОНД БРУЦЕЛЛЭЗЫН ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДАХ ТӨЛ МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

2024 оны 07 дугаар сарын 30 өдөр

№	Сумын нэр	2024 онд дархлаажуулалтад хамрагдах эм төл (тол)				Шаардагдах вакцины хэмжээ		Вакцины үнэ (мян/төг)	Шингэлэг ч (литр)	Шингэлэг ч үнэ (мян/төг)	Нийт вакцин, шингэлэгчийн үнэ (мян/төг)
		Тугал	Хурга	Ишиг	Бүгд	Br.abort us-19 омог	Br.Meliten sis Rev-1				
						343.1	203.0			6.600	
1	Алаг-эрдэнэ	3,767	39,207	26,558	69,532	3,767	65,765	14,642,753	73,299	483,773	15,126,526
2	Арбулаг	3,748	52,010	29,343	85,101	3,748	81,353	17,800,598	88,849	586,403	18,387,001
3	Баянзүрх	3,798	42,760	21,245	67,803	3,798	64,005	14,296,109	71,601	472,567	14,768,675
4	Бүрэнтогтох	9,905	106,660	66,471	183,036	9,905	173,131	38,543,999	192,941	1,273,411	39,817,409
5	Галт	2,028	17,597	8,223	27,848	2,028	25,820	5,937,267	29,876	197,182	6,134,448
6	Жаргалант	2,405	23,961	10,117	36,483	2,405	34,078	7,742,990	38,888	256,661	7,999,650
7	Их-уул	2,136	25,306	18,971	46,413	2,136	44,277	9,721,093	48,549	320,423	10,041,516
8	Мөрөн	4,649	48,279	34,755	87,683	4,649	83,034	18,450,974	92,332	609,391	19,060,365
9	Рашаант	1,545	25,445	9,506	36,496	1,545	34,951	7,625,143	38,041	251,071	7,876,213
10	Ренчинлхүмбэ	2,539	28,491	6,991	38,021	2,539	35,482	8,073,977	40,560	267,696	8,341,673
11	Тариалан	3,205	20,688	13,640	37,533	3,205	34,328	8,068,220	40,738	268,871	8,337,090
12	Тосонцэнгэл	3,112	44,548	19,131	66,791	3,112	63,679	13,994,564	69,903	461,360	14,455,924

14	Түнэл	4,663	44,825	31,831	81,319	4,663	76,656	17,161,043	85,982	567,481	17,728,525
15	Улаан-уул	4,760	23,695	10,176	38,631	4,760	33,871	8,508,969	43,391	286,381	8,795,350
16	Ханх	3,539	4,882	4,574	12,995	3,539	9,456	3,133,799	16,534	109,124	3,242,923
17	Хатгал	3,385	5,485	6,243	15,113	3,385	11,728	3,542,178	18,498	122,087	3,664,264
18	Цагааннуур	574	2,809	1,844	5,227	574	4,653	1,141,498	5,801	38,287	1,179,785
19	Цагаан-уул	5,673	84,138	36,973	126,784	5,673	121,111	26,531,939	132,457	874,216	27,406,156
20	Цагаан-үүр	1,830	1,645	956	4,431	1,830	2,601	1,155,876	6,261	41,323	1,197,199
21	Цэцэрлэг	5,548	47,322	32,924	85,794	5,548	80,246	18,193,457	91,342	602,857	18,796,314
22	Чандмань-өндөр	1,968	2,992	3,321	8,281	1,968	6,313	1,956,760	10,249	67,643	2,024,403
23	Шинэ-идэр	2,557	39,047	17,681	59,285	2,557	56,728	12,393,091	61,842	408,157	12,801,248
24	Эрдэнэбулган	3,069	8,586	6,821	18,476	3,069	15,407	4,180,595	21,545	142,197	4,322,792
		83,383	775,000	455,000	1,313,383	83,383	1,230,000	278,298,707	1,396,766	9,218,656	287,517,363